

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

МАЛЫН ҮРЖИЛ, ТЕХНОЛОГИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ С.САМДАНГИЙН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, сүргийн зохистой бүтцийг хадгалах, түүхий эд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.							
1.	Арга хэмжээ 1.1 Өвөлжилтийн бэлтгэл ажил, өвс тэжээлийн аюулгүй нөөцийн бүрдүүлэлтийг хангаж ажиллах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.1.1 дэхь заалт	Биелэлтийн хувиар		2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 80 хувиас доошгүй хангасан байна.	Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай 2025 оны 09 дугаар 03-ны өдрийн А/553 дугаар захирамжийг үндэслэн Сумын Засаг даргын 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/115 дугаар захирамжаар Засаг даргын орлогчоор ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан өвөлжилтийн бэлтгэл	2025.08.20 2025.12.05	100

					хангах 3 бүлэг 15 заалт бүхий нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан заалт тус бүрээр нь хэрэгжүүлэн ажиллаж биелэлт 84.5 хувьтай хангагдсан. 1.Сумын аюулгүй нөөц бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралтаар сумын аюулгүй нөөцөд бүдүүн тэжээл-108тн, хүчит тэжээл-93тн, эрдэс тэжээл-0,2тн бэлтгэхийг тогтоож өгсөн. Сумын аюулгүй нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Өв-Агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит компаниас 937 боодол буюу 28.1 тн ногоон тэжээл, сумын ногоон тэжээл тариалсан иргэдээс 2000 боодол буюу 50тн, нийт 78тн ногоон тэжээлийг худалдан авч сумын аюулгүй нөөцөд бүрдүүлсэн. 1. Малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээл Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн ахлагч Б.Дэмбэрэл гишүүн	
--	--	--	--	--	---	--

					С.Самдан Д.Мөнхбат нар малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлтэй танилцаж тэдний санал хүсэлтийг сонсож зөвлөмж мэдээлэл өгсөн. Нэг малчин өрх дунджаар 0.8 тн тэжээл, 1-2 тн байгалийн хадлан өвс, 2.4 тн ногоон тэжээл худалдан авч өвөлжилтийн бэлтгэлээ хангаж байна. Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралтаар тус сум малчдын түвшинд бүдүүн тэжээл-1764тн, хүчит тэжээл-591тн, эрдэс тэжээл-1143 тн-г тус тус бэлтгэхийг тогтоож өгсөн. Үүнээс малчдын түвшинд бүдүүн тэжээл-1770тн, хүчит тэжээл-2831тн, эрдэс тэжээл-854тн-г тус тус бэлтгэсэн.		
2.	Арга хэмжээ 1.2. Бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар	Эдийн засгийн эргэлтэд оруулсан малын тоогоор	13.9 мянган толгой мал зах зээлд борлуулсан.	Таваарын малын 5-аас доошгүй хувийг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	Малчдад эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг Хужирт цахим тв болон цахим фейж хуудас, багийн Засаг дарга нараар дамжуулан уриалж 2025 оны жилийн эцсийн байдлаар Адуу-4892, үхэр-3126, хонь-21869, ямаа-10841 нийт-40728 толгой мал буюу нийт зах зээлд борлуулбал зохих малын 63.7 хувийг эдийн засгийн эргэлтэд	2025.01.01 2025.12.05	100

	зорилт 8.1.2 дахь заалт				оруулж, хүнсэнд хэрэглэсэн байна. Мах махан бүтээгдэхүүн үнээс адууны мах-23,2тн, үхрийн мах-94тн, хонины мах-24,1тн, ямааны мах-7,04тн нийт 148,4тн махыг дотоодын зах зээлд борлуулсан байна.		
3	Арга хэмжээ 1.3. Малын тоо толгойн албан татварыг бүрэн төвлөрүүлэх, хуулийн дагуу зарцуулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.1.3 дахь заалт	Төвлөрүүлж ,зарцуулсан төсвийн дүнгээр	112.7 сая төгрөг төвлөрүүлж 80.0 сая төгрөг зарцуулсан.	Малын тоо толгойн албан татварын төвлөрүүлэлт ийг нэмэгдүүлнэ.	2020 оны 11 дүгээр сарын 13-ний өдөр батлагдсан малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 2 багт хуваагдан малын тоо толгойн албан татварын үлдэгдэлтэй байгаа малчдад татварын улсын байцаагчийн нэхэмжлэх бичгийг бичгээр өгч, утсаар холбогдон мэдээлэл хүргэж ажиллаж байна. Сумын хэмжээнд 2022 онд 191,060,400 төгрөг төвлөрөхөөс 54.9% буюу 105,000,000 сая төгрөг, 2023 онд 208,029,400 төгрөг төвлөрөхөөс 38.4% буюу 80,000,000 сая төгрөг, 2024 онд 192,402,800 төгрөг төвлөрөхөөс 46.8% буюу 192,402,800 төгрөг тус тус төвлөрсөн байна. Малын тоо толгойн албан татварт татварын орлогын төлөвлөгөө 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 100000,0 мянган төгрөг төвлөрөхөөс 116800,1 мянган төгрөг	2025.01.01 2025.06.10	100

					төвлөрсөн байна.		
4	Арга хэмжээ 1.4. Бог малын хээлтүүлэгч болон эрчимжсэн аж ахуйн үхрийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлт, баяжилт, ашиглалтыг сайжруулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.1.7 дахь заалт	Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн малын тоогоор		2024 оны жилийн эцсийн малын тооны баяжилт, тулгалтыг 1391 малчин, мал бүхий өрхийн 245924 малын мэдээллийг шинэчлэн, баяжилт хийнэ.	1391 малчин болон мал бүхий өрхийн баяжилт, малчдын мэдээлэл болон шинээр нэмэгдсэн малчдын мэдээллийг нэмж, нас барсан, шилжсэн төлөвтэй малчдыг идэвхгүй болгож программын шинэчлэлт хийж 245924 толгой малын шинэчлэлтийг хийж мөн мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг малчин өрх бүрээр шивж малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг бүрэн оруулж дуусгасан. Тус суманд 2025 онд бог малын хээлтүүлэгчийг гэрээт 4-н малчны суурт хуц-715, ухна-345 ялган төвлөрүүлсэн. 2025 оны 3 дугаар улиралд хээлтүүлэгч малын 2 суурьт үзлэг, ангилалтын ажлыг зохион байгуулж мал эмнэлгийн тасагтай хамтран 356 хуц, 184 ухна , 3 бухнаас цусны дээж авч, бруцеллёз өвчний шинжилгээнд хамруулахад өвчлөл илрээгүй мөн 30 хуц, 30 уханд хянан баталгаа хийж биеийн хэмжээ авч, амьдын жинг тодорхойлж, 356 хуц, 184 ухна, 3 бух, эрчимжсэн аж ахуйн 56 үхрийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн.	2025.01.01 2025.06.10	100

5	Арга хэмжээ 1.5. Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.1.8 дахь заалт	Ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгчийн тоогоор	Хуц-702, ухна-347 толгойг ялган төвлөрүүлсэн.	2025 онд хуц-720, ухна-350 толгойг ялган төвлөрүүлнэ.	Тус суманд бог малын хээлтүүлэгчийг гэрээт 4-н малчны суурт хуц-715, ухна-345 нийт 1060 толгой хээлтүүлэгч малыг ялган төвлөрүүлсэн байна.	2025.01.01 2025.06.10	100
6	Арга хэмжээ 1.6. "Малын индексжүүлсэн даатгал"-д нийт малчин өрхийн 5-аас доошгүй хувийг хамруулах ажлыг зохион байгуулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.1.9 дэх заалт	Даатгалд хамрагдсан малчин өрхийн тоогоор	23 өрхийн 1241 толгой малыг даатгалд хамруулсан.	Нийт 1273 малчин өрхийн 5-аас доошгүй хувийг хамруулсан байна.	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл нийт малчин өрхийн 3.7 хувь буюу 48 малчин өрхийн 4531 толгой мал малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байна.	2025.01.01 2025.06.10	70
Зорилт 2. Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, хоршоодыг чадавхжуулна							
7	Арга хэмжээ 2.1. " Мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.4.2 дахь заалт	Дэмжсэн аж ахуйн нэгжийн тоо,		Мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн байна.	Хэрэгжээгүй.		
Зорилт 3. Мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулна							
8	Арга хэмжээ 3.1. Үхэр,	Нийт мал	Нийт сүргийн	Өндөр ашиг	Нийт мал сүрэгт адуу-13%, үхэр-8%-	2025.01.01	100

	болон өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малыг эдийн засгийн эргэлтэд оруулан тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Сумын засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2 дугаар зорилт 3.2.1.1 дэх заалт	сүрэгт үхэр сүргийн эзлэх хувь, эдийн засгийн эргэлтэд оруулсан малын тоогоор	8 хувийг үхэр сүрэг эзэлж байна. 13.9 мянган толгой мал зах зээлд борлуулсан	шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд анхаарч, таваарын малын 5-аас доошгүй хувийг эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	ийг тус тус эзэлж байна. Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор Арц ганга нэгдэл хоршоо сүүний чиглэлийн Алатау үүдрийн 18, Урт хөндлөн ивээл хоршоо хосолмол ашиг шимт Симменталь үүдрийн 24, Мөнхөд өрнөн өсөх, Жамбал талбиун эрдэнэ хоршоо нь махны чиглэлийн Сэлэнгэ, Казакийн цагаан толгойт үүлдрийн 81, Товогийн ширээ хоршоо сүүний чиглэлийн Монбельярд үүлдрийн 4 үхэр тус тус худалдан авч цэврээр үржүүлж, сайжруулагчаар ашиглаж байна. Хоршоо, аж ахуй нэгж болон малчид сүүний чиглэлийн-176, Мах сүүний чиглэлийн-157, Махны чиглэлийн-81 толгой нийт 414 толгой үхрийг өсгөн үржүүлж байна. Адууг уналга, эдэлгээ-махны болон хурдны чиглэлээр үржүүлэх зорилгоор Владимир, Буденны үүлдрийн азаргыг сайжруулагчаар ашиглан үржүүлж байна. Хонин сүргийн ашиг шим, таваарлаг байдлыг нэмэгдүүлэхийн тулд малчид Баянгол омгийн 10 хээлтүүлэгч, Баяд үүлдрийн 5 хээлтүүлэгч, Барга үүлдрийн 2 хээлтүүлэгч, Хотонт үржлийн хэсгийн 5 хээлтүүлэгчийг тус тус малчид худалдан авалт хийж сүргийн бүтцэд сайжруулагчаар	2025.12.10	
--	---	---	--	---	--	------------	--

					ашиглан мах, ноосны гарцыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна. Мөн Эдельба үүлдрийн 25 хуц, 20 хээлтэгч, суффолк үүлдрийн 2 хуц худалдан авч хэрэгцээний эрлийзжүүлэг хийж гарсан төлийг зах зээлд борлуулж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна. Шилмэл мал-2025 үзэсгэлэн худалдааг зохион байгуулж шилмэл хээлтүүлэгчийг шалгаруулсан. Үүнд: Шилмэл азаргаар 1. Өвөрмодот 1-р багийн малчин Ц.Мөнхнасангийн хээр азарга 2. Дулаан 6-р багийн малчин Д.Даваасүрэнгийн зээрд азарга 3. Шунхлай 5-р багийн малчин Ч.Доржсүрэнгийн хээр азарга 3. Шунхлай 5-р багийн малчин О.Бат-Эрдэний хээр азарга Шилмэл бухаар 1. Өвөрмодот 1-р багийн малчин Ц.Мөнхнасангийн хар бух 2. Шивээт 4-р багийн малчин С.Анхбаярын ягаан 3. Шивээт 4-р багийн малчин С.Анхбаярын бор Шилмэл Хуцаар 1. Дулаан 6-р багийн малчин Т.Баттулгын хар хүзүүтэй хуц 2. Өвөрмодот 1-р багийн малчин Г.Мандахбаярын хар нүдэн хуц	
--	--	--	--	--	--	--

					3. Өвөрмодот 1-р багийн малчин М.Давгын хар халзан хуц Шилмэл ухнаар 1. Дулаан 6-р багийн малчин Т.Баттулгын бор ухна 2. Өвөрмодот 1-р багийн малчин Г.Мандахбаярын хар ухна 3.Бэрх 3-р багийн малчин Ё.Дамдингомбын ухна тус тус шалгарсан. Малчдад эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг Хужирт цахим тв болон цахим фейж хуудас, багийн Засаг дарга нараар дамжуулан уриалж 2025 оны жилийн эцсийн байдлаар Адуу-4892, үхэр-3126, хонь-21869, ямаа-10841 нийт-40728 толгой мал буюу нийт зах зээлд борлуулбал зохих малын 63.7 хувийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хүнсэнд хэрэглэсэн байна. Мах махан бүтээгдэхүүн үнээс адууны мах-23,2тн, үхрийн мах-94тн, хонины мах-24,1тн, ямааны мах-7,04тн нийт 148,4тн махыг дотоодын зах зээлд борлуулсан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт үхэр сүргийн 10 хувийг буюу 3126 толгой үхэр зах зээлд борлуулж болон хүнсэнд хэрэглэсэн байна.		
9	Арга хэмжээ 3.2. Залуу	Хэрэгжүүлсэ	Малжуулах	Залуу	Төрөөс малчид, мал аж ахуйн	2025.01.01	100

	малчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж малчдыг чадавхжуулна. Сумын засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2 дугаар зорилт 3.2.1.7 дахь заалт	н арга хэмжээ, хамрагдсан малчдын тоогоор	арга хэмжээнд 15 малчныг хамруулсан.	малчдыг малжуулах арга хэмжээнд 10-с доошгүй малчныг хамруулж залуу малчдыг туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулна.	үйлдвэрлэлийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг танилцуулах, малчид, мал аж ахуй эрхлэгчдийн тэргүүн туршлагыг солилцох, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, санал санаачилгыг орон нутгийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, мал сүргийг эрүүлжүүлэхэд малчдын анхаарах асуудал, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаж байгаа байдал, малын үүлдэр угсааг сайжруулахад юуг анхаарах, цаашдын зорилт, малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулж зах зээлд нийлүүлэх, төсөл хөтөлбөртэй хэрхэн хамтран ажиллах талаар мэдлэг олгох, мөн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх тэдний санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 07-ний өдөр малчдын зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулсан. Малчдын зөвлөгөөнд Боловсролын яамны эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх О.Цэцэгбал, Бор аварга сангийн тэргүүн үндэсний бөхийн улсын аварга С.Мөнхбат, аймгийн ХХААГазар, Мал эмнэлгийн газрын холбогдох албан хаагчид,	2025.06.10	
--	---	--	---	--	---	-------------------	--

					Монгол ВИ-ТИ-НЕТ төрийн бус байгууллагын малын их эмч Наранбаатар, МУСТА Дуучин Г.Машбат, МУСТА Дуучин Г.Эрдэнэтунгалаг болон сумын удирдлагууд болон 453 малчдын төлөөлөл оролцсон зөвлөгөөн болсон. Зөвлөгөөнд Хөдөө аж ахуйн салбар, Улсын аварга малчдын тэргүүн туршлага, хууль эрх зүй, нийгмийн даатгал, татвар, бэлчээр газар тариалан, эрүүл мэнд, хөдөлмөр халамж, мал маллахын хажуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрхэн орлогоо нэмэгдүүлэх талаарх холбогдох албан хаагчдыг модератор, панелистаар оролцуулж малчдад мэдээлэл хүргэж хамтран ажилласан. Мөн залуу малчдыг дэмжих, малчны тухай тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8.-д заасан гамшигт болон аюулт үзэгдэлд нийт мал сүргийнх нь 50 хувиас доошгүй нь өртсөн малчин өрх, эсхүл хонин толгойд шилжүүлснээр 250 хүртэл малтай, эсхүл 16-40 хүртэлх насны малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулах гэсэн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Өвөрхангай аймгийн Хөдөлмөрийн	
--	--	--	--	--	--	--

					хэлтсээс 2025 онд нэг малчин 8.0 сая төгрөгийн малжуулах төсөл хөтөлбөрт хамрагдуулсан. Мөн Өвөрмодот 1 дүгээр багийн сумын сайн малчин Л.Жамбалсүрэн тус багийн малчин Б.Баянмөнхийг 5 хургатай хониор тус тус малжуулсан.		
Зорилт 4. Малчдын хоршоог чадавхжуулна.							
10	Арга хэмжээ 4.1. Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана. Сумын засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2 дугаар зорилт 3.2.3.2 дахь заалт	Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоогоор	Мал аж ахуйн чиглэлээр 11-н хоршоо байгуулагдсан.	Малчдад сургалт сурталчилгаа мэдээлэл хүргэж ажиллана.	Төрөөс хоршооны чиглэлээр баримталж буй бодлого шийдвэр, Хоршоог хэрхэн байгуулах, анхаарах асуудлыг малчдад, танилцуулах, малчид, мал аж ахуй эрхлэгчдийн тэргүүн туршлагыг солилцох, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, санал санаачилгыг орон нутгийн бодлого шийдвэр, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулж зах зээл нийлүүлэх, төсөл хөтөлбөртэй хэрхэн хамтран ажиллах талаар мэдлэг олгох, мөн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх тэдний санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 07-ний өдөр малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөнд аймгийн хоршоологчдын холбооны гишүүн З.Баярсайхан, Зээлийн батлан даалтын сангийн аймаг дахь	2025.01.01 2025.06.10	100

					салбарын захирал Д.Бямбадолгор нарыг урин оролцуулж малчид, хоршоологчдод зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Зөвлөгөөнд малчдын 14 хоршооны малчид оролцсон 2025 онд шинээр 4 хоршоо шинээр байгуулагдсан байна.		
Зорилт 5. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах							
11	Арга хэмжээ 5.1 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. Албан тушаалын тодорхойлолт 5 дугаар зорилт 6 дахь заалт:	Хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухай бүрд биелүүлэх Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу урд оны материалыг архивлан холбогдох албан хаагчид хүлээлгэн өгөх, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Өвөрхангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга Батсуурь-аар ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 07-ний өдөр тус суманд ажиллаж хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн ажил байдалтай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мөн үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр тусгасан ажил үйлчилгээний хэрэгжилтийн явц үр дүн, Аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр тусгасан ажил үйлчилгээний хэрэгжилтийн явц үр дүн, хоршоо хөгжүүлэх сангийн программ ашиглалт, зээлийн хүртээмж, эргэн төлөлтийн байдал	2025.01.01 2025.12.15	100

					зэрэг 17 чиглэлээр хяналт шалгалт хийж зөвлөмж мэдээлэл хүргэж ажилласан. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Архи согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих” тухай удирдамжийн дагуу 8-н нэрийн 22 хүнсний дэлгүүр , 6-н нэрийн 1 хүнсний дэлгүүрт Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хорооны гишүүд болон хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний хамт хугацаа дууссан бүтээгдэхүүнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 2.518.350 төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг буцаан татан авалт, хугацаа дууссан 2.912.600 төгрөгийн бараа бүтээгдэхүүний дэлгүүрийн өөрсдийн дотоод журмаар устгуулан ажилласан.		
12	5.2 Өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган	Төлөвлөгөө ний хэрэгжилтийг бүрэн хангасан байна		Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тогтоол шийдвэрийн биелэлт, хэрэгжиж буй үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг гарган	2025.01.01 2025.12.15	100

	холбогдох мэргэжилтэнд өгөх Албан тушаалын тодорхойлолт 5 дугаар зорилт 8 дахь заалт:			шийдвэрийн эхний хагас жилийн биелэлт, хугацаатай тайлан мэдээг тогтмол гарган тайлагнах	Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж тайланг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар болон холбогдох албан тушаалтанд цаг тухай бүрд нь гарган ажиллаж байна. Өвөрхангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт тус сумаас 2025 онд гадны аймаг сум болон аймаг дотроо хийж буй отор нүүдлийн судалгаа, малын индексжүүлсэн даатгал хамрагдсан малчид, ээмэгжүүлж бүртгэлжүүлсэн мал, зах зээлд борлуулсан малын судалгааг тус тус холбогдох маягтын дагуу гаргаж өгсөн.		
--	---	--	--	--	--	--	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Хувь
	1	2	3	4	5	6	7
13	1. Ажлын чиг үүрэгт хамаарах болон өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх Албан тушаалын тодорхойлолт 3 дугаар	Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулах сургалтын		Мэргэжил ур чадвараа нэмэгдүүлэх сургалтад тухай бүр хамрагдсан байна.	Бүсчилсэн хөгжил хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан Миний нутаг сайхан Иргэдийн спортын наадамд Шагайн харвааны төрөлд сумаа төлөөлөн оролцож Хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлж, 2025 оны 04 дүгээр сарын 06-	2025.01.01 2025.12.15	100

	зорилт 5 дахь заалт:	хөтөлбөрт хамрагдсан байна.			ний өдөр Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан Хангайн бүс, Говийн бүс, Төвийн бүс, Баруун бүс, Зүүн бүсээс шигшээд шалгарсан багуудын аварга шалгаруулах тэмцээнд оролцож гутгаар байр эзэлсэн. 2025 оны 04 дүгээр сарын 11-13-ний өдрүүдэд Хангайн бүсийн сумдын төрийн албан хаагчдын нөхөрсөг уулзалт, спортын арга хэмжээ тус суманд зохион байгуулагдаж спортын шагайн харвааны төрөлд тэргүүн байр, эрэгтэй гар бөмбөгийн төрөлд гутгаар байр, олс таталтын төрөлд тэргүүн байр тус тус эзэлсэн. Өвөрхангай аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн нэгдсэн сургалт, семинарыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Өвөрхангай аймагт зохион байгуулж сургалтад сумын Засаг дарга болон хөдөө аж ахуйн тасгийн 3 мэргэжилтэн тус тус хамрагдсан. Мэдээлэл технологийн ажилтантай хамтран 2025 оны 5 дугаар сараас эхлэн Хужирт цахим тв пэйж хуудсыг ажиллуулан хөтлөгчөөр ажиллаж 7 хоногт 2-3 мэдээ бэлтгэж олон нийтийн сүлжээнд нийтлэн иргэдэд мэдээллийг үнэн бодит түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.		
--	----------------------	-----------------------------	--	--	---	--	--

14	Бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр, эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллана.	Бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын үед сумын онцгой комиссын бүрэлдэхүүнд орж хариуцлагатай жижүүр, эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан байна.	Бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын үед 1 удаа ажилласан.	Бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр, эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллана.	Өвөрхангай аймгийн онцгой байдлын газар, тус сумын эрэн хайх аврах бүлэг сумын онцгой комисс хамтран багуудад хуваагдаж болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвийн айл өрхүүдээр орж цахилгааны аюулгүй байдалд хяналт тавьж, зөвлөмж мэдээлэл хүргэж, ил задгай үнс нурмаа асгахгүй байх, шар өвс болон ил задгай хог хаягдал шатаахгүй байхыг анхааруулж ажилласан. Мөн Хархорин сум дахь онцгой байдлын хэлтэс, тус сумын эрэн хайх аврах бүлгээс зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож зөвлөмж мэдээлэл авсан. 2025 оны 10 дугаар сарын 27-28-ний өдрийн тус сумын эрэн хайх аврах бүлгийн албан хаагчтай хамтран Шунхлай 5 дугаар багийн Гуа хорооллын хуваарьт газрын айл өрхүүдээр болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг хүргэж цахилгааны утасны аюулгүй байдал, үнс нурмаа эл задгай асгахгүй байх тал дээр шалгалт хийж зөвлөмж мэдээлэл хүргэж ажилласан. Мөн хогоо ангилдаг Хужиртчууд “Хамтдаа шийдье” уриалгыг өрх бүр хүрт хүргүүлж мэдээ мэдээлэл хүргэж	2025.01.01 2025.12.15	100
----	--	--	--	--	--	--------------------------	-----

					ажилласан.		
15	Арга хэмжээ 2. Компьютер дээр монгол бичгийн үсгийн фонд суулгаж унших, бичих чадвараа сайжруулах	Монгол бичгийн уншиж, бичих чадвараа дээшлүүлсэн байх	Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй.	Компьютер дээр монгол бичгийн үсгийн фонд суулгасан байна.	Монгол бичгийн унших бичих чадварыг дээшлүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газраас Б.Нямсүрэн багшаар монгол бичгийн хичээлийг заалгаж байна. Өөрийн хэрэглээний компьютер дээр монгол бичгийн фондыг суулгаад байна.	2025.01.01 2025.12.15	100
16	Арга хэмжээ 3. Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн мэдлэгээ нэмэгдүүлэх	-	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдаж хуулийн мэдлэгээ нэмэгдүүлнэ.	Өвөрхангай аймгийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааны АЗ сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 15-16-ний өдрүүдэд Өвөрхангай аймагт 2 өдөр зохион байгуулагдаж тус сургалтад хамрагдсан.	2025.01.01 2025.12.15	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

МАЛЫН ҮРЖИЛ,
ТЕХНОЛОГИЙН АУИЛ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

(Албан тушаал)

..... / С.САМДАН/

(Нэр, гарын үсэг)

.....

(Огноо)